



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/22

Өлгий

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Усны тухай хуулийн 28.6 заалт, Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны даргын 2022 оны 05-р сарын 14-ний өдрийн 19 дүгээр тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Усны тухай хуулийн 28-ийн 6 дахь заалтыг үндэслэн “Өлгий Толбо тур” ХХК-д ус ашиглан аялал жуулчлал эрхэлж үйл ажиллагаа явуулахад шаардлагатай 4680м^3 усыг нэг жилийн хугацаагаар ашиглах зөвшөөрөл олгосугай.

2. Усны тухай хуулийн 29.1, 18.1.4 дэхь заалтыг үндэслэн “Өлгий Толбо тур” ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулж ажиллахыг БОАЖГ-ын мэргэжилтэн Б.Гүлжанд үүрэг болгосугай.

3. Усны тухай хуулийн 30 дугаар зүйл дэхь заалтуудын дагуу ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ тайланг дараа оны 1-р улиралд багтаан ирүүлэхийг “Өлгий Толбо тур” ХХК -ны гүйцэтгэх захирал / Т.Наранцэцэг/-т даалгасугай.

4. Усны ашиглах боломжит нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Толбо сумын байгаль хамгаалагч Х.Сураган-д үүрэг болгосугай.

